

Монгол хэл 5-р анги

18оноо

Ижийтэйгээ үзсэн тэр жилийн наадам

Ижийтэйгээ үзсэн тэр жилийн наадам
Цэцэг нар хоёртоо бахардсан наадам
Ижийтэйгээ үзсэн тэр жилийн наадам
Чихэр инээд хоёртоо бялуурсан наадам
Наадамчдын зулай дээр
Нар голлон халуун байсан ч
Элбэг дээл шиг
Ижийнхээ сүүдэрт хярахад сэрүүхэн
Дан эмжээртэй
Даалимбан дээлнээс минь
Даавууны шинэхэн үнэр
Сэнгэнэх нь даанч сайхан.
Над шиг гоё хүнгүй
Тэр жилийн наадам
Нар хур тэнцсэн
Тэр жилийн наадам.
Долоогийн даваа
Нар хэвийлгэн шувтарч
Даага ирлээ! гэсэн шуугиан
Наадмын хөндийг дүүргэсэн сэн...
Тосон ирсэн хоёр тоос
Бичигтийн хөндийд томолдож
Тоос тоосны дундаас
Зургаан даага сугарсан сан...
Хошуу сүүл даран

Хоорондоо их ойрхон
Барияны газар
Бараа саахалтын хэртэй
Бэлчээрт хүрсэн нь л түрүүлнэ гэсэн аархал
Эмээл бүхэн дээр ноцож байхад
Бичигт хадны сүг зураг
Татвалзаж байх шиг санагдсан...
Хөтөлгөө гүүтэй өвгөн уяач хажууд байсныг
Хөөрч догдлохдоо би хараагүй байж...
Зөв талын дөрөөн сэнж хан хийлгэн
Жингэнэтэл үүрсэн хөтөлсөн гүү нь тэлүүлэв.
Зургаад нь явсан буурал даага
Зуузай даран янцгааснаа сүүл нь годойж
Хаанаас гарсан ид шид нь энэ вэ гэлтэй
Хар хурдаараа яралзан барианд магнайлав.
Хөлсийг нь хусахын зав өгөлгүй
Хөхөө хөхөх гэж эх рүүгээ шунгав.
Эхийнхээ дууг сонссон
Эсгэл даага сум юм билээ.
Ингэдэг гэдгийг нь мэддэг
Хашир уяач нум юм билээ.
Ижийтэйгээ үзсэн тэр жилийн наадам
Цэцэг нар хоёртоо бахардсан наадам
Ижийтэйгээ үзсэн тэр жилийн наадам
Чихэр инээд хоёртоо бялуурсан наадам

Б.Лхагвасүрэн

1. Асуултад хариулаарай.

/1оноо/

- “Элбэг дээл шиг
Ижийнхээ сүүдэрт хярахад сэрүүхэн” гэж дүрсэлсэн хэсэгт ямар санааг агуулж байна вэ?

.....
.....

2. Шүлгийн гол санаа аль нь вэ? сонгоорой

/1оноо/

- A. Ижийтэйгээ үзсэн тэр жилийн наадам чихэр, цэцэг хоёр элбэг байв.
- B. Ижийтэйгээ үзсэн тэр жилийн наадмын дааганы уралдаанд хашир уяачийн даага түрүүлсэн.
- C. Тэр жилийн наадамд ижийтэйгээ ирсэн хүү хамгийн их баяр баясгалантай байсан. Мөн уралдаанд эхтэйгээ ирсэн даага түрүүлсэн. Энэ бол эхийн хайр юм.
- D. Эхийнхээ дууг сонссон, эсгэл даага сум юм билээ. Ингэдэг гэдгийг нь мэддэг хашир уяач нум юм билээ.

3. Үгсийг дүрэмтэй нь зөв харгалзуулаарай.

/2оноо/

ангил	Э.Г-ээр төгссөн үгэнд "л" дагавар залгасан	савла
сумла	З.Г-ээр төгссөн үгэнд "л" дагавар залгасан	хээл
багцал	Эгшгээр төгссөн үгэнд "л" дагавар залгасан	даршил
ирлэ		тухал
товчил		ундаал

4.Өгөгдсөн өгүүлбэрийг зурагтай нь харьцуулаад, яагаад эцэг эх нь хүүхдийнхээ үйлийг дэмжихгүй байгааг хоосон нүдэнд баталж тайлбарлаарай. /2оноо/



- Зөндөө удаан цаг суучхаад одоо болтол дуусаагүй юмуу?

Ээжийн зөв. Яагаад гэвэл даалгавраа тодорхой цагт хийж сурах хэрэгтэй. Чадахгүй зүйл тулгарвал эцэг эхийнхээ тусламжийг авах нь илүү үр дүнтэй байдаг.



- Миний охин битгий уйл! Чамд зөндөө тоглоом байгаа шүү дээ.



- Аавыгаа жаахан хүлээхгүй дээ. Чи үүнийг хийж үзээгүй болохоор ийм болголгүй яах вэ дээ?

5.Онцсогуудыг таагаад хэтрүүлэл, хүншүүллийн аргаар дүрсэлсэн хэсгийг ялган бичнэ үү. / 5оноо/

Ах нь өдөр харна.
 Дүү нь шөнө харна. |.....|
 Навтгар эмгэн
 Наян хумстай |.....|
 Дэлгэх бие нь дэлмийн чинээ
 Дэлгэрэх үг нь дэлхийн чинээ |.....|

Хүншүүлсэн	Хэтрүүлсэн

6. Хэлц үгийг ойролцоо утгатай хэлц үгээр солин найруулж бичээрэй. /3оноо/

Бат багшийнхаа өмнө амаа үдүүлсэн юм шиг зогсов.

Ээж минь намайг алган дээрээ бөмбөрүүлсэн.

Манай ангийн Анар онигоо ярьж бид нарын элэг хөших дөхлөө.

7.Бүтцийн дагуу үлгэр зохиохдоо төлөвлөн бичье. /4оноо/

- Үлгэр зохиох сэдвээ сонгоорой.

Найз нөхөрлөлийн тухай

Эрэлхэг зоригт баатрын тухай

Залхуу хойрго хүний тухай

Эцэг эхийн ачлалын тухай

- Сонгосон нэг сэдвээ үйл явдлыг төлөвлөн товч бичээрэй. /30-40 үгтэй/

Эхлэл хэсэг

Гол хэсэг

Төгсгөл хэсэг

Сургууль..... Анги Сурагчийн нэр.....

Математик 5-р анги

1. Бутархайг жишээрэй.

/2оноо/

2.151 ... 2.184 1.821 ... 1.80 2.113 ... 2.103 5.06 ... 5.05

2. Уншаад, аравтын бутархайн стандарт хэлбэрийг харгалзуулна уу.

/2оноо/

- | | |
|--|--------|
| А. Тавин зургаан бүхэл зууны найм | 5.608 |
| Б. Тавин зургаан бүхэл мянганы найм | 56.8 |
| В. Тавин зургаан бүхэл аравны найм | 56.008 |
| Г. Таван бүхэл мянганы зургаан зуун найм | 56.08 |

3. Зөв хариуг сонгоорой.

/3 оноо/

$$\frac{4}{7} + \frac{2}{14} =$$

А. $\frac{6}{14}$

Б. $\frac{10}{14}$

В. $\frac{6}{7}$

А. $\frac{6}{21}$

Хэмжээг өгсөн нэгжээр илэрхийлээрэй. \ 80 ар = м.кв.\

А. 8000м.кв

Б. 800м.кв

В. 80000м.кв

Адил хажуут гурвалжны оройн өнцөг 40° бол бусад өнцгүүдийг олоорой.


А. 80°, 60°

Б. 70°, 70°

В. 100°, 200°

4. Заасан чиглэлд параллель зөөж зураарай.

/1оноо/



5. Сурагч Анужингийн шалгалтын дүн өгөгджээ. Уг өгөгдлийн **арифметик дундаж** болон **далайцыг** олоорой


/2оноо/

Сурагчийн нэр	Шалгалтын дүн (гүйцэтгэлийн хувиар)				
	Математик	Англи хэл	Монголын түүх	Физик	Газарзүй
Анужин	67	59	71	66	71

Арифметик дундаж:


Далайц:

6. Будсан дүрсийг параллелаар зөөсөн бн. Аль чиглэлд хэдэн нэгжээр зөөснийг бичээрэй. /2оноо/




Дүрсийг..... чиглэлд нэгж зөөсөн.

8. Тавдугаар ангийн дугуйланд суралцдаг хүүхдийн тоог дугуй диаграммаар харуулав. Дугуйг 6 тэнцүү хуваасан болно. 10 сурагч математикийн дугуйланд суралцдаг бол хэдэн сурагч англи хэл ба биеийн тамирын дугуйланд сурдаг вэ?



- Математикийн дугуйланд сурдаг
- Англи хэлний дугуйланд сурдаг
- Биеийн тамирын дугуйланд сурдаг

9. Тэгш өнцөгт параллелолипед савны урт нь 12м, өргөн нь 5м, өндөр нь 9м байлаа. Уг савны 3-ны 2 хэсгийг усаар дүүргэв Хэдэн литр ус орсон вэ? /3оноо/



7. Оюун 3 дугаар сарын 24-нд төрсөн Бат Оюуны төрсөн өдрөөс 24 хоногийн дараа төрсөн бол Бат хэдэн сарын хэдний өдөр төрсөнбэ?

/1 оноо/

1 сар <small>Да Мя Лх Пү Ба Бя Ня</small>	2 сар <small>Да Мя Лх Пү Ба Бя Ня</small>	3 сар <small>Да Мя Лх Пү Ба Бя Ня</small>	4 сар <small>Да Мя Лх Пү Ба Бя Ня</small>
1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14 15 16 17 18 19 20 21 22 23 24 25 26 27 28 29 30 31	1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14 15 16 17 18 19 20 21 22 23 24 25 26 27 28	1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14 15 16 17 18 19 20 21 22 23 24 25 26 27 28 29 30 31	1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14 15 16 17 18 19 20 21 22 23 24 25 26 27 28 29 30
5 сар <small>Да Мя Лх Пү Ба Бя Ня</small>	6 сар <small>Да Мя Лх Пү Ба Бя Ня</small>	7 сар <small>Да Мя Лх Пү Ба Бя Ня</small>	8 сар <small>Да Мя Лх Пү Ба Бя Ня</small>
1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14 15 16 17 18 19 20 21 22 23 24 25 26 27 28 29 30 31	1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14 15 16 17 18 19 20 21 22 23 24 25 26 27 28 29 30	1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14 15 16 17 18 19 20 21 22 23 24 25 26 27 28 29 30 31	1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14 15 16 17 18 19 20 21 22 23 24 25 26 27 28 29 30 31
9 сар <small>Да Мя Лх Пү Ба Бя Ня</small>	10 сар <small>Да Мя Лх Пү Ба Бя Ня</small>	11 сар <small>Да Мя Лх Пү Ба Бя Ня</small>	12 сар <small>Да Мя Лх Пү Ба Бя Ня</small>
1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14 15 16 17 18 19 20 21 22 23 24 25 26 27 28 29 30	1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14 15 16 17 18 19 20 21 22 23 24 25 26 27 28 29 30 31	1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14 15 16 17 18 19 20 21 22 23 24 25 26 27 28 29 30	1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14 15 16 17 18 19 20 21 22 23 24 25 26 27 28 29 30 31

/2оноо/